

“МИК Холдинг” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2024 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн хурлын
24/04 дугаартай тогтоолын Хавсралт



ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Процессын ангилал:	Засаглал
Хувилбарын дугаар:	1.0 (Анхны хувилбар)
Баримт бичгийн төлөв:	Хүчин төгөлдөр
Хэлэлцэж эцэслэсэн:	2024 оны 02 сарын 13 өдөр
Батлагдсан:	2024 оны 02 сарын 13 өдөр (Төлөөлөн удирдах зөвлөлийн 24/04 дугаартай тогтоол)
Эргэн хянах:	2024 оны 8 сарын өдөр
Боловсруулсан нэгж:	Стратеги төлөвлөлт, судалгааны газар
Хяналт тавих:	ТХХ
Хамаарах газар нэгж:	“МИК Холдинг” ХК болон түүний охин компаниудын ТУЗ, ГУ болон бүх газар нэгж

БАРИМТ БИЧГИЙН ТҮҮХ			
Хувилбарын дугаар	Батлагдсан (Он, сар, өдөр)	Товч утга	Боловсруулсан нэгж
1.0	2024.02.13	Анхны хувилбарыг хэлэлцэн батлав.	СТСГ

АГУУЛГА

1.	Нийтлэг үндэслэл	3
2.	Тогтвортой байдлын эрхэм зорилго (Sustainability Mission Statement)	3
3.	Тогтвортой хөгжлийн зарчмууд.....	3
4.	Тогтвортой хөгжлийн зарчмын биелэлтийг хэмжих үзүүлэлтүүд.....	4
5.	Бодлогын үнэлэлт, сайжруулалт	4

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

1. Нийтлэг үндэслэл

- 1.1. МИК Холдинг ХК болон түүний охин компаниуд нь /цаашид “МИК Холдинг” гэх/ Бидний оршин буй харилцан уялдаа бүхий эх дэлхийд нийтлэг тулгамдаад буй уур амьсгалын өөрчлөлт, нийгмийн тэгш бус байдал болон бизнесийн ёс зүйн асуудлыг шийдвэрлэхэд чухалчлан оролцохын ач холбогдлыг хүлээн зөвшөөрч байна.
- 1.2. Дээрх асуудлуудад анхаарал хандуулах нь манай группын хувьцаа эзэмшигчдийн нийтлэг сонирхол байх бөгөөд мөн Монгол Улсын зохицуулагч төрийн байгууллагуудын шинээр нэвтрүүлж буй дүрэм журмууд нь үүнийг дэмжиж байна.
- 1.3. Иймд МИК Холдинг нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Тогтвортой хөгжлийн зорилгууд болон Байгаль орчин, нийгэм, засаглалын зарчмуудын ач холбогдлыг чухалчлан харж, хариуцлагатайгаар хүлээн авч байна. Үүгээр бид үйл ажиллагааны бүхий л шатанд төдийгүй хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хоёрдогч зах зээл дээрх үйл ажиллагааныхаа ирээдүйн хэв загварыг энэхүү зарчимд нийцүүлэн өөрчлөх зорилгоо дэвшүүлж байна.
- 1.4. МИК Холдинг нь өөрийн алсын хараа болох “Монгол өрхийн тав тухтай амьдралыг дэмжих орон сууцны санхүүжилтийн экосистемийг бүрдүүлэх”-дээ байгаль орчин, нийгэм, засаглалын зарчмуудыг нэвтрүүлж манлайлан ажиллахаар болсон нь бидний стратегийн шийдвэр гэдгийг тодотгон дурдаж байна.

2. Тогтвортой байдлын эрхэм зорилго (Sustainability Mission Statement)

- 2.1. Бид өөрсдийн үйл ажиллагааг байгаль орчинд ээлтэй нөлөөлөл үзүүлэх, нийгмийн тэгш хүртээмжтэй нөхцөлийг бүрдүүлэх, шийдвэр гаргалтын ёс зүйн өндөр хэмжээс бүхий засаглалын тогтолцоог бүрдүүлэх чиглэлд хөтөлснөөр харилцан уялдаа бүхий эх дэлхийн тогтвортой ирээдүйд хувь нэмрээ оруулж буй хариуцлагатай алхам гэж үзнэ.

3. Тогтвортой хөгжлийн зарчмууд

- 3.1. МИК Холдинг нь Орон сууцны санхүүжилтийн тасралтгүй байдлыг хангах замаар ипотекийн зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэхдээ дараах зарчмуудыг баримтлан хэрэгжүүлнэ. Үүнд:

Байгаль орчинд ээлтэй үйл ажиллагааг дэмжих чиглэлээр

- 3.1.1. Эрчим хүчний хэмнэлттэй, дулаан алдагдал багатай орон сууцны болон арилжааны хөрөнгүүдийг үнэт цаасжуулах үйл явцыг илүүтэй чухалчлан авч үзнэ.
- 3.1.2. Сэргээгдэх эрчим хүч болон ногоон дэд бүтэц бүхий байгууламжуудыг илүүд үзэн дэмжин ажиллана.
- 3.1.3. Хот сууринд утааны голомт болж буй байршил дахь яндангийн тоог шууд бууруулах байгууламжийг чухалчлан авч үзнэ.

Нийгмийн тэгш хүртээмжтэй нөхцөл бүрдүүлэх чиглэлээр

- 3.1.4. Бага орлоготой иргэдэд чиглэсэн зээлийн нөхцөл бий болгох санаачилгыг дэмжин төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллана.
- 3.1.5. Зээлийн хэмжээ болон нөхцөлийн орлогод нийцсэн байдлыг нийтлэг мөрдүүлэх замаар ядуурлыг бууруулахад дэмжлэг үзүүлнэ.
- 3.1.6. Санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор жендерийн эрх тэгш байдлыг хангах, санхүүгийн үйлчилгээ хязгаарлагдмал бүлгийг дэмжихэд анхаарч ажиллана.

Шийдвэр гаргалтад тогтвортой хөгжлийн ёс зүйг баримтлах чиглэлээр

- 3.1.7. Шийдвэр гаргалтын бүхий л шатанд тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг суулгана.
- 3.1.8. Тогтвортой хөгжилтэй уялдаатай эрсдэл ба боломжийг байнга тайлагнана.

- 3.2. МИК Холдинг нь бусад үйл ажиллагааны бүхий л шатанд дараах зарчмыг баримтлан хэрэгжүүлнэ. Үүнд:

Байгаль орчныг хамгаалах чиглэлээр

- 3.2.1. Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах зорилтыг тодорхойлж, биелүүлж ажиллана.
- 3.2.2. Байгаль орчин, биологийн олон янзын байдлыг хамгаалах санаачилгыг дэмжиж, хэрэгжүүлж ажиллана.

Нийгмийн тэгш хүртээмжтэй нөхцөл бүрдүүлэх чиглэлээр

- 3.2.3. Хүний эрхийг хүндэтгэж, хөдөлмөрийн стандартыг мөрдөж, ажилтнуудыг хөдөлмөрийн шударга, аятай нөхцөлөөр хангана.
- 3.2.4. Сонгон шалгаруулалт, дадлагажуулалт, албан тушаал дэвшүүлэх үйл явцад жендерийн эрх тэгш байдлыг хангах бөгөөд бүх төрлийн жендерт суурилсан ялгаварлан гадуурхалтаас ангид байна.

Шийдвэр гаргалтад тогтвортой хөгжлийн ёс зүйг баримтлах чиглэлээр

- 3.2.5. Оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэсэн, хамтын ажиллагааг дэмжсэн, тэгш хүртээмжтэй харилцааг эрхэмлэнэ.

4. Тогтвортой хөгжлийн зарчмын биелэлтийг хэмжих үзүүлэлтүүд

Доорх үзүүлэлтүүд нь хамтрагч талын баримтлах үзүүлэлтүүдтэй уялдан өөрчлөгдөх боломжтой.

Байгаль орчны чиглэлээр

- 4.1. **Ногоон дэд бүтэц:** тухайн нутаг дэвсгэрт ногоон байгууламж, ногоон дэд бүтцийн хэмжээ нэмэгдсэн эсэхийг үнэлэх
- 4.2. **Агаарын чанар:** тухайн бүс нутгийн агаарын чанарын үзүүлэлт сайжирсан эсэхийг үнэлэх

Нийгмийн тэгш байдлыг хангах чиглэлээр

- 4.3. **Хүн амын нягтрал:** тухайн төсөл хэрэгжиж буй нэгж нутаг дэвсгэрт амьдарч буй хүн амын нягтрал зохистой хэмжээнээс хэтэрсэн эсэхийг үнэлэх
- 4.4. **Нийтийн тээвэр:** тухайн газар нутагт нийтийн тээврийн хүртээмж, үйлчилгээ сайжирсан байдлыг үнэлэх
- 4.5. **Нийгмийн дэд бүтэц:** тухайн төсөл хэрэгжиж буй нэгж нутаг дэвсгэрт цэцэрлэгт хүрээлэн, сургууль, цэцэрлэг худалдаа үйлчилгээний хүртээмж хангагдсан эсэхийг үнэлэх

5. Бодлогын үнэлэлт, сайжруулалт

- 5.1. Энэхүү бодлого нь бусад улс, байгууллагын тэргүүн туршлага болон зохицуулалтын орчны өөрчлөлт, байгууллагын бүхий л талын оролцогч нарын зөвлөмж зэрэг асуудлуудыг нэгтгэн харгалзаж үнэлэлт дүгнэлт хийгдэж байх бөгөөд түүнд уялдуулсан байнгын сайжруулалтыг хийж, бодлогын бичиг баримтад шаардлагатай өөрчлөлтүүдийг тусгаж байна.
- 5.2. Энэхүү бодлогын хэрэгжилт, түүний тайланг хагас жил тутамд МИК Холдинг ХК-ийн Төлөөлөх удирдах зөвлөлийн дэргэдэх Тогтвортой хөгжлийн хороо танилцаж хянахын дээр Гүйцэтгэх удирдлагад тодорхой дүгнэлт чиглэл өгч байх бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөлд тайлагнана.